



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум  
Утас: 70592439, 70592208, 70593208  
E-мэйл: dundgovi@audit.gov.mn

**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ШУДАРГА ИРГЭДИЙН НЭГДСЭН  
ЭВСЭЛ НАМД**

2020.07.30 № 105  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын 2020 оны сонгуульд оролцох Дундговь аймаг дахь Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох Дундговь аймаг дахь Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Дундговь аймаг дахь Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл намын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг,

0012020386

“Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Дундговь аймаг дахь Шударга Иргэдийн Нэгдсэн Эвсэл нам”- ын мөрийн хөтөлбөр / 4 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймагийн сонгуулийн хороонд

Хавсралт 4 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  П.ТӨВСАНАА



## ДУНДГОВЬ АЙМГИЙН ШИНЭ НАМЫН “ШИНЭ ДУНДГОВЬ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монголын ард түмэн, Монгол Улсын язгуур эрх ашгийг үндэс болгож, нийгмийн бүхий л давхаргын эрх ашгийг эн тэнцүү ханган хамгаалдаг улс төрийн социал-демократ үзлийг баримтлан Монгол орныг цогцлоон хөгжүүлэх “Шинэ Дундговь” мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд энэхүү мөрийн хөтөлбөрийг Дундговь аймгийн ШИНЭН -аас дэвшүүлж байна.

**Нэг. Улс төрийн бодлого** /Орон нутагт намчирхал, талцлыг таслан зогсооно /

1.1 Бүх шатны сонгуулийн үр дүн харгалзалгүйгээр, эе эвийг хичээн нутаг орноо удирдах зарчмыг тууштай баримтална.

1.2 Аймгийн хэмжээнд хүний нөөцийн “Алтан сан”-г нас, хүйс, үзэл бодол, намын харьяалал үл харгалзан үүсгэж, төрийн албаны шаардлага хангасан иргэдийг холбогдох хуулийн дагуу сонгон шалгаруулах замаар ажлын байраар хангаж байх бодлогыг тууштай баримтална.

1.3 Орон нутагт намын харьяаллаар ялгаварлан хавчиж ажлаас халдаг гаж үзэгдлийг таслан зогсоож, боловсон хүчнийг мэдлэг, мэргэжил, ур чадвар, мэргэшилд нь тохирсон ажлын байраар хангана.

1.4 Авлига, хээл хахуулиас ангид, үнэнч шударга, ёс суртахуунтай, хариуцлагатай төрийн албыг орон нутагт бүрдүүлэн, төрийн албаны тогтвортой байдлыг хангаж ажиллана.

1.5 Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадварт суурилсан төрийн албан хаагчдын ёс зүйд суурилсан чадавхыг дээшлүүлснээр аливаа хүнд суртал, иргэдийг чирэгдүүлэх асуудлыг цэгцэлнэ.

**Хоёр. Эдийн засаг, бизнесийг дэмжих бодлого** / Орон нутгийн төсвийн зарцуулалтад хатуу хяналт тогтооно /

2.1 Сум бүрийн онцлогт тохирсон хөгжлийн хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж эхэлнэ.

2.2 Аймагт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагыг зээл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэх бодлогыг тууштай баримтална.

2.3 Аймгийн төсвийн зарцуулалтад тавих иргэдийн хяналтыг төгөлдөржүүлж, төсвийг зориулалтыг бусаар зарцуулдаг байдлыг таслан зогсооно.



2.4 Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд аймгийн харьяалалтай иргэдийг ажлын байраар хангах явдлыг хөхиүлэн дэмжинэ.

**Гурав. Шинэ, шуурхай цахим Дундговь** /Орон нутгийн ИТХ, Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг мэдээллийн бүхий л хэрэгсэл, олон нийтийн сүлжээг ашиглан тогтмол мэдээлэлж, байнгын, бодит, өгөөжтэй эргэх холбоог бий болгоно. /

3.1 Орон нутгийн ИТХ, Төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг мэдээллийн бүхий л хэрэгсэл, олон нийтийн сүлжээг ашиглан тогтмол мэдээлэлж, байнгын, бодит, өгөөжтэй эргэх холбоог бий болгоно

3.2 Интернетийн хурдыг нэмэгдүүлж, орон нутгийн түвшинд иргэд интернет ашиглах чадварыг сайжруулна.

3.3 Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.

3.4 Төрийн байгууллагад мэдээлэл, харилцаа холбооны технологийн зохистой хэрэглээг нэвтрүүлэх, байгууллага хооронд сайн туршлага хуваалцах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулна.

3.5 Иргэдэд төрөөс үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай, хүнд сурталгүй, хялбар, энгийн ойлгомжтой болгох талаар төрийн захиргааны байгууллагууд болоод тухайн тойргоос сонгогдсон УИХ-н гишүүдтэй нягт хамтран ажиллана.

**4. Нийгмийн бодлого** /Тухайн орон нутгийн иргэдийн хамтарч, хоршиж ажиллах аливаа санал, санаачлагыг дэмжиж ажиллана/

4.1 Сумдад өндөр настан иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөгжлийн төвийг бий болгоно.

4.2 Сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамралтыг өргөжүүлэх зорилгоор хүний нөөц, барилга байгууламжийг судлан мэдээллийг дээд шатны байгууллагад хүргэж, шийдвэрлүүлэх бүхий л боломжийг судалж ажиллана.

4.3 Жил бүрийн төсөв, орон нутгийг хөгжүүлэх санд тусгайлсан хөрөнгө суулгах замаар “Хүүхдийн парк”-ийг иж бүрэн тохижуулна.

4.4 Жил бүрийн төсөв, орон нутгийг хөгжүүлэх санд тусгайлсан хөрөнгө суулгах замаар “Шинэ ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлж томоохон хэмжээний тоглоомын талбайнуудыг бий болгож иж бүрэн тохижуулна.

4.5 Урлаг, спортыг дэмжиж, хүүхэд, залуучуудын оюун санаа, бие бялдрын хөгжилд онцгой анхаарна.

4.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чадамжид суурилсан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна. Эдгээр иргэдэд шинээр ажлын байр бий болгож буй үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжинэ.



СЭМИН Н  
ДУНД  
АИМ  
0469211  
НУТГИЙН

4.7 Аймгийн нийгэм, эдийн засгийн салбарт инновацид суурилсан хөрөнгө оруулалт, технологийн шинэчлэл хийх явдлыг хөхүүлэн дэмжинэ.

4.8 Орон нутгийн хүн амын өсөлтийг дэмжиж, иргэн бүрийн эрүүл мэндэд онцгойлон анхаарч, эмнэлгийн чанартай, хүртээмжтэй үйлчилгээгээр хангана.

4.9 Тахилгат уул овоо, малын бэлчээр, өвөлжөө хаваржаа, булаг шандын эх, рашаан бүхий газарт ашигт малтмалын хайгуул, олборлолт явуулахыг хориглох эрх зүйн зохицуулалт бий болгохын төлөө ажиллана.

4.10 Усны хэрэглээг зохистой болгож, нуур цөөрөм, булгийн эх, рашааныг төрийн хамгаалалтад авч, сэргээх ажлыг хэрэгжүүлнэ.

4.11 Аймгийн хэмжээнд экосистемийг нөхөн сэргээх чадавхыг хадгалах, цөлжилтийн эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг эрчимжүүлж, сумдад мод, бут сөөг тариалж буй аж ахуйн нэгж, албан байгууллагыг бодлогоор дэмжинэ.

## 5. Аймгийн төвийн хөгжил

5.1 Нийтийн өмч, зам талбайн ашиглалт, хамгаалалт, эрүүл ахуйн нөхцөл байдал, орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтад тухайн орон нутгийн иргэдийн сайн дурын оролцоог эрс нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

5.2 Төв суурин газрын гудамж, орчны тоосжилтыг эрс бууруулах талаар иргэдийн оролцоонд суурилсан санаачилга гарган ажиллана.

5.3 Аймгийн төвийн цэвэр, бохир усны нэгдсэн системд холбогдсон айл өрхүүдэд ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж байрлуулах, хэрэглээний халуун усаар хангах хөтөлбөр хэрэгжүүлж, иргэдийн эрүүл, тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

5.4 Аймгийн төвд шинээр суурьшиж буй айл өрхүүдийг цахилгаан, дэд бүтэц, ундны усаар бүрэн хангах асуудлыг шийдвэрлэнэ.

5.5 Аймгийн төвийн гудамж, замын дагуу зүлэг ногоо, мод тарих ажлыг эрчимжүүлж, **“Шинэ Ногоон Мандалговь”** хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

5.6 **“Шинэ Гэрэлтэй Мандалговь”** төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээр аймгийн төвийн автозам, гудамж талбайн гэрэлтүүлгийг сайжруулна.

5.7 **“Хоггүй Мандалговь”** төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээр аймгийн төвийн хогийг ангилах, боловсруулах боломжийг бий болгох, иргэдийг соён гэгээрүүлэх замаар хоггүй Мандалговь болно.

## 6. Сумын хөгжил

6.1 Сумдыг нэгдсэн халаалтын системд холбох ажлыг ээлж дараатайгаар шийдвэрлэн, шаардагдах санхүүжилтийг улсын төсвийн болон орон нутгийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр гүйцэтгэнэ.



Official stamp and signature of the authority.

6.2 Сумын төвийн ундны усны хангамжийн асуудлыг бодитойгоор шийдвэрлэж, чанарын шаардлага хангасан усан хангамжийг үе шаттайгаар бий болгоно.

6.3 Хүн амын нягтаршил болон эдийн засгийн бусад үзүүлэлтүүдийг харгалзан хүн эмнэлэг, сургууль цэцэрлэгийн барилга шинээр барих болон сэргээн засварлах дарааллыг тогтоож, шаардагдах хөрөнгийг ээлж дараатайгаар улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ.

6.4 Сум бүрт орон сууцжуулах хөтөлбөрийг эхлүүлнэ.

6.5 “Хоггүй сум” төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээр хогоо ангилах, ангилсан хогоо аймгийн төвийн хогтой холбох боломжийг бий болгох, иргэдийг соён гэгээрүүлэх замаар хоггүй сумтай болно.

## 7. Хөдөөгийн хөгжлийн бодлого

7.1 Бэлчээрийн нөөц газруудад уст цэг, худаг гаргах замаар бэлчээрийн даацыг нэмэгдүүлж, зохистой ашиглах бодлого баримтална.

7.2 Малчдаас өрхийн бүлэг, хоршоо, малын түүхий эд боловсруулах жижиг үйлдвэрлэл байгуулах ажиллагааг дэмжиж ажиллана.

ШИНЭ намын Дундговь аймгийн ОНЗ

2020 оны 6 сарын 24

